



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 606

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар нийт 1.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал /Ц.Уранчимэг/-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Барилга болон автомашины ашиглалтын хувийн хэргийг холбогдох журмын дагуу тогтмол хөтөлж, хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг зөв тооцож, бүртгэл хөтлөх;

2.2. Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө гарган, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 6.-ны өдрийн
606. дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Эрүүл мэндийн хүрээлэнд зөвшөөрөлгүй ашиглуулсан 12 м2 төрийн өмчийн талбайн ашиглалтын зардал	Захирал Ц.Уранчимэг, Ерөнхий санхүүч Ш.Гантуяа	0.3	-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг; -Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”; -Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай” 119 дүгээр тогтоол.	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
2	Төрийн өмчийн байранд ашиглахгүй байгаа талбайг бусдад түрээслүүлэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай түрээсийн гэрээ байгуулаагүй (ХААН банкны ATM машин, Ундааны автомат машин)	Захирал Ц.Уранчимэг, Ерөнхий санхүүч Ш.Гантуяа	1.1		
Нийт дүн			1.4		